



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/157

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.9, Монгол Улсын сангийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн “Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай” 188 дугаар тушаал, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4.1.3, аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/561 дүгээр захирамжаар батлагдсан “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн 2.1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Гүйжөү мужид 2024 оны 03 дугаар сарын 06-аас 03 дугаар сарын 09-ний өдрүүдэд албан томилолтоор ажиллах төлөөлөгчдийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 25,421,000 (хорин таван сая дөрвөн зуун хорин нэгэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0340

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 28-ны өдрийн 115 дугаар
захирамжийн хавсралт



БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ГҮЙЖӨҮ МУЖИД
АЛБАН ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ЗАМЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Чиглэл	Зардал	Нийт зардал
1.	Улаанбаатар-Бээжин-Гүйжөү- Бээжин-Улаанбаатар	1,746,800x9хүн 2 талдаа	15,721,200
2.	Буудал	250,000x4хоног 9 хүн	9,000,000
3.	Зам хоног	50(s)x4 хоног	700,000
Нийт			25,421,000

Долларын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн ханшаар тооцов.
1 доллар=3500 төгрөг

-оОо-